

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ 02 ДУГААР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар хуралдааныг 10 цаг 00 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 76.9 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо батлах тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийг хариуцаж ажиллах Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийн асуудал хариуцсан менежер (ахлах мэргэжилтэн), Цахим засаглалын асуудал, төрийн үйлчилгээний нэгдсэн портал хариуцсан мэргэжилтэн;</p> <p>2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст Аймгийн Ерөнхий архитекторч, хот төлөвлөлт, газрын харилцааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтэн, Инноваци, иргэний болон үйлдвэрлэлийн барилгын төлөвлөлт, стандартын асуудал хариуцсан мэргэжилтэн гэсэн 5 албан тушаалыг шинээр нэмэх;</p> <p>4. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалыг Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн, Зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалыг Авто зам, тээвэр логистикийн асуудал хариуцсан мэргэжилтэн;</p> <p>5. Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, урлаг, биеийн тамир, спортын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалыг Соёл, урлаг, биеийн тамир, спорт, соён гэгээрүүлэх асуудал хариуцсан мэргэжилтэн гэж тус тус өөрчлөлт оруулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн тогтоолыг шинэчлэн баталж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.</p>
2	Орон нутгийн өмчийн газрын бүтэц, үйл ажиллагааны чиглэлийн талаар	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 25 агентлаг ажиллуулахаар тогтоосны дагуу Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны албаны бүтэц, орон тоог батлах захирамжийн төслийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулж, танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд, Санхүү,</p>

		төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг дарга нарт үүрэг болгов.
3	Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлын журам	ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлын журмыг хэлэлцэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал тусган, сайжруулалт хийж батлуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР